



2024 оны зургадугаар сарын 03

Эрхэм хамт олон танаа,

“Лоро Пиана” компанийн түүх нь чанар, үнэн зөв, шударга байдал, өндөр ур чадвар зэрэг үнэт зүйлсүүд дээр үргэлж суурилсаар ирсэн. Ёс суртахуунтай, тогтвортой байдал нь бидний амжилт, өсөн дэвжилтийн үндэс болдог гэдэгт тууштай итгэхийн зэрэгцээгээр бид бүгдийн үүрэг бол үлгэр жишээ чанд байдлыг сахиж, эдгээр удирдах зарчмуудыг хэрэгжүүлэх элч нь болж, өдөр тутмын үйл ажиллагаандаа тусгахад оршино гэж бид үзэж байна.

Ёс зүйн дүрэмд манай компанийн хэрэгжүүлж буй үнэт зүйлс, өдөр тутмын үйл ажиллагааны уялдаа холбоог баталгаажуулж, бидний үйл ажиллагаа, сэтгэлгээний хэв маягийг тодорхой тусгаж заасан болно.

"Лора Пиана" компани нь LVMH Группээс баталсан зарчим, онцлог чанаруудыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд энэ нь манай компанийн өвөрмөц гүн ухаан, ДНХ-тэй бүрэн уялдаж, тусгагдсан байдаг тул LVMH Группийн Ёс зүйн дүрмийг өөрийн Ёс зүйн дүрэм болгон баталсан.

Эдгээр зарчим нь бид бүгдийн болон "Лоро Пиана" компанид ажилладаг, тус компанитай хамтран ажилладаг, хамаарал бүхий хүн бүрийн ажиллах горимыг зааж чиглүүлдэг.

Миний зүгээс та бүхнийг тус Ёс зүйн дүрмийг оффис, дэлгүүр, үйлдвэрт хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаандаа гарын авлага болгож, анхааралтай уншиж танилцахыг хүсэж байна.

Хамтран ажилласанд баярлалаа.

Дэмиен Бертран

Агуулга

Тэргүүний мэндчилгээ	2
Гүйцэтгэх хорооны үүрэг амлалт	3
Группын үнэ цэнэ	4
Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх, түгээх	6
Үүрэг амлалт хүлээсэн групп	10
Үндсэн эрхийг эрхэмлэн дээдлэх.....	10
Хүрээлэн буй орчныг хамгаалах	11
Түншүүд болон ханган нийлүүлэгчдийн дунд хариуцлагатай хандлагыг сурталчлах	13
Хариуцлагатай ажил олгогч	15
Эелдэг, хүртээмжтэй ажлын орчныг дэмжих	15
Ажлын байран дээрх амьдралын чанарыг хангах	16
Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах	17
Үнэнч шударга групп	19
Авлигатай тэмцэх	19
Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	19
Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх	20
Олон улсын хориг арга хэмжээг дагаж мөрдөх.....	20
Чөлөөт, гажуудалгүй өрсөлдөөнийг дэмжих	21
Нууцлал хадгалах.....	22
Санхүүгийн зах зээлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийхээс урьдчилан сэргийлэх	23
Хувь хүний нууцыг хүндэтгэх.....	24
Олон нийтийн ажилд хариуцлагатай оролцох.....	25

Тэргүүний мэндчилгээ

Компанийн жинхэнэ ололт амжилт бол цаг хугацааны шалгуурыг давж, тогтвортой нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулах амжилт юм.

LVMH болон манай Maison-уудын хувьд энэхүү эртний итгэл үнэмшил нь бидний бүтээгдэхүүн, үүрэг амлалт, үйл ажиллагаанд өдөр бүр биелэлээ олж байдаг.

Дэлхий дахинаа танигдсан бүтээгдэхүүнүүдийнхээ ачаар бид амжилтанд хүрсэн. Дээд зэргийн чанарыг эрэлхийлэх бидний эрэл нь эдгээр бүтээгдэхүүний дур татам шинж чанарыг бий болгодог бол уг дур татам шинж чанарыг манай гар урчуудын онцгой үр чадварын бүтээдэг.

Энэ нь мөн манай Maison-уудын байнга шинэчлэгдэж байдаг бүтээлч байдал, шинэлэг санаа, олон улсад нээлттэй явуулдаг үйл ажиллагаанаас үүдэлтэй. Maison бүр бидний нэр хүндтэй өв соёлыг тогтвортой байлгахын төлөө ажиллаж байна.

Түүнчлэн бид дэлхийн өнцөг булан бүрт ёс зүй, шударга байдал, нийгмийн хариуцлага, байгаль орчныг эрхэмлэн дээдлэх дээд хэм хэмжээг сахин биелүүлэхийн төлөө түүштай үүрэг амлалт өгч, анхаарч ажилладгаараа эртнээс танигдаж ирсэн.

Эдгээр үүрэг амлалтаа илэрхийлэх үүднээс бидний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх зарчим, дүрмийн хэлбэрт оруулан энэхүү Ёс зүйн дүрмийг бүрэн шинэчиллээ.

Үүнд тогтвортой байдлын бүхий л хүчин зүйлсийг багтаан, нарийвчлан тусгасан болно.

Энэхүү дүрэмд заасан зарчим, дүрмийг аль болох цогц, нарийвчилсан байлгахыг зорьж буй бөгөөд тус дүрэмд сүүлийн хэдэн жилийн хугацаанд бичигдсэн бусад баримт бичгүүдийг мөн дурдсан болно. Эдгээр нь хамтдаа LVMH болон түүний ажилчдын үйл ажиллагааг зохицуулах бидний ёс зүйн тогтолцоог бүрдүүлнэ.

LVMH-ийн бүх ажилчид эдгээр зарчмуудыг даган мөрдөж, биечлэн хэрэгжүүлэх ёстой гэдгийг онцлох нь зүйтэй.

LVMH-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Ёс зүй, Тогтвортой Хөгжлийн Хороо эдгээр зарчмуудыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.

Группын Гүйцэтгэх хорооны гишүүд тус тусын хариуцсан салбартаа эдгээр үүрэг амлалтыг сурталчлах болно.

Нэмж дурдахад, Maison-ы ерөнхийлөгч болон тэдний ажилчид энэхүү нийтлэг ёс зүйн тогтолцоог өөрийн болгож, зарчмыг нь биечлэн хэрэгжүүлэх ёстой.

Ингэснээр бид урт хугацааны амжилтаа баталгаажуулах болно.

Бернард Арно
LVMH-ийн Тэргүүн, Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэх хорооны үүрэг амлалт

Гүйцэтгэх хорооны гишүүд энэхүү Ёс зүйн дүрэмд тусгагдсан зарчмуудыг сурталчлахад оруулах ёстой үүрэг хариуцлагаа ухамсарлаж, тус тусын чиг үүргийн хүрээнд эдгээр үүрэг амлалтыг сурталчлах болно.

ANTONIO BELLONI
GROUP MANAGING DIRECTOR

DELPHINE ARNAULT
CHRISTIAN DIOR COUTURE

NICOLAS BAZIRE
DEVELOPMENT AND ACQUISITIONS

PIETRO BECCARI
LOUIS VUITTON

STÉPHANE BIANCHI
WATCHES & JEWELRY

MICHAEL BURKE
FASHION GROUP

CHANTAL GAEMPERLE
HUMAN RESOURCES AND SYNERGIES

JEAN-JACQUES GUIONY
FINANCE

CHRIS DE LA PUENTE
SELECTIVE RETAILING

STÉPHANE RINDERKNECH
LVMH HOSPITALITY EXCELLENCE & BEAUTY

PHILIPPE SCHAUS
WINES & SPIRITS

JÉRÔME SIBILLE
GENERAL ADMINISTRATION & LEGAL AFFAIRS

JEAN-BAPTISTE VOISIN
STRATEGY

Группын үнэ цэнэ

LVMH Групп (цаашид "LVMH" эсвэл "Групп" гэх) нь 75 гаруй Maison-уудаас бүрдэх бөгөөд Дарс, спирт; Хувцас загвар ба арьсан эдлэл; Үнэртэй ус, гоо сайхны бүтээгдэхүүн; Цаг, үнэт эдлэл; Сонгомол жижиглэнгийн худалдаа болоод Бусад үйл ажиллагаа зэрэг тансаг зэрэглэлийн зургаан томоохон салбарт үйл ажиллагаа явуулдаг цорын ганц тоглогч юм.

Группийн ололт амжилт болоод урт удаан хугацаанд оршин тогтнож буй явдал нь түүний соёлыг бүрдүүлж, бүх ажилчдын чиг үүргийг удирдан чиглүүлэгч үнэт зүйлс, зарчмуудад үндэслэсэн байдаг

Бүтээлч, инновацлаг байх

Бүтээлч байдал, инновацлаг байх нь бидний ДНХ-ийн нэг хэсэг бөгөөд энэ нь олон жилийн турш манай Maison-уудын амжилтын түлхүүр байсаар ирснээс гадна хууль ёсны байдлынх нь үндэс суурь юм. Maison-ууд нь бүтээлч байдал болоод инноваци дээр суурилсан бөгөөд энэ нь өвөрмөц өв соёлоо үргэлжид эрхэмлэхийн сацуу санал болгож буй бүтээгдэхүүнүүдээ байнга шинэчлэн, ирээдүй өөд түүштай зүтгэхэд нарийн тэнцвэртэй байдлыг бий болгож байдаг.

Дээд зэргийн чанарыг бий болгох

Группын зүгээс чанарын хувьд аливаа эрсдэл гаргадаггүй бөгөөд Maison-ууд нь бүтээгдэхүүнээс эхлээд үйлчилгээ хүртэлх бүхий л үе шатанд нарийн деталь бүрт анхаарал хандуулж, төгс төгөлдөрт хүрэхийг эрмэлзэн гар урлалын ертөнцөд хамгийн эрхэмсэг, чадварлаг байдлыг бий болгодог. Групп нь төгс чанарыг эрэлхийлдгээрээ бусдаас ялгардаг.

Бизнесийн эрхлэх мөн чанарыг төлөвшүүлэх

LVMH групп нь LVMH-ийн үр ашигтай, хариуцлагатай байдлыг дэмжих шүүрхай, төвлөрсөн бус зохион байгуулалттай. Мөн хүн бүрт чухал үүрэг хариуцлага хүлээлгэн хувь хүний санаачлагыг дэмждэг. Группын хөгжүүлж буй бизнес эрхлэх мөн чанар нь эрсдэлтэй алхам хийх болон шаргуу зан байдалд хөшүүрэг болдог. Энэ нь мөн бодит байдлыг олж харахын зэрэгцээ удирдаж буй багаа ирээдүйтэй зорилгод хөтлөх урам зориг өгөх чадвартай байхыг шаарддаг.

Эерэг нөлөө үзүүлэхийн төлөө тууштай байх

Групп болон түүний ажилчдын хийж буй үйлдэл бүр нь LVMH-ийн ёс зүй, компанийн нийгмийн хариуцлага, байгаль орчныг хүндэтгэх үүрэг амлалтыг илэрхийлж байдаг. Энэхүү үүрэг амлалт нь Maison-уудын гүйцэтгэлийг удирдан чиглүүлж, урт хугацааны тогтвортой амжилтыг нь хангадаг. Зөвхөн тогтвортой бизнес л чин хүсүүштэй бүтээгдэхүүнийг бий болгоно гэх бат итгэл дээр үндэслэн Групп нь илүү сайн сайхан ирээдүйг бүтэээхэд идэвхтэй хувь нэмрээ оруулж, Группын бүтээгдэхүүн болоод бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй үйл явц нь нийт экосистемд нь эерэг нөлөө үзүүлнэ гэдгийг хангахыг зорьж буй.

Засаглал

LVMH Групп нь ёс суртахууны хүчтэй соёлоо аль болох өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх үүднээс Группын дүр төрх, үйл ажиллагааны бодит байдал, төвлөрсөн бус үйл ажиллагааны арга барилд нийцсэн засаглалын бүтцийг бий болгосон.

Энэхүү бүтцэд удаах зүйлс багтана:

- Группын үйл ажиллагаанд тулгуурласан хувь хүн болон нийтлэг үнэт зүйлсийг хүндэтгэх байдалд хяналт тавьдаг **Төлөөлөн удирдах зөвлөлийн Ёс зүй, тогтвортой хөгжлийн хороо нь дараах үндсэн үүрэгтэй:**
 - Нийгэм, байгаль орчин, үүр амьсгалын өөрчлөлтийн асуудлаар Группын үндсэн стратегийг тодорхойлоход нь Төлөөлөн удирдах зөвлөлд туслах мөн дээд түвшний удирдлага, ажилтнуудын зан үйлийг удирдан чиглүүлэх ёс зүйн дүрмийг боловсруулахад туслах;
 - эдгээр дүрмийг дагаж мөрдөхөд хяналт тавих; ба
 - бий болсон тогтолцоонуудыг хянах.
- **LVMH Группын Тэргүүн, Гүйцэтгэх захирал ба Гүйцэтгэх хорооны гишүүд** нь ёс зүй, нийгэм, байгаль орчны хариуцлагын чиглэлээр группын үүрэг амлалтыг сурталчлах;
- Энэхүү Ёс зүйн дүрмийн зарчмуудыг тус тусын салбарт түгээн дэлгэрүүлэх, ажилтнууддаа зохих ёсоор дагаж мөрдөхийг хангах **Maison-уудын ерөнхийлөгчид;**
- Группийн үйл ажиллагааны хэлтсүүдээс бүрдэх **Группын Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо** нь Группын стратегийн ёс зүй, нийгэм, байгаль орчны үүрэг хариуцлагын зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, удирдан чиглүүлдэг бөгөөд уг хороо нь эдгээр чиглэлээр Группын санаачилгыг хэрэгжүүлэхэд идэвхтэй тусалж дэмжин, нэгдсэн тайланг холбогдох мэдээллээр хангадаг мэргэшсэн харилцааны мэргэжилтнүүдийн сүлжээнд тулгуурладаг;
- LVMH-ийн ёс зүй, нийцлийн арга барилыг удирдан чиглүүлж, зохицуулдаг **Ёс зүй ба нийцлийн хэлтэс** нь Maison бүрийн ерөнхийлөгчийн томилсон харилцааны мэргэжилтнүүдийн сүлжээнд тулгуурладаг бөгөөд чиг үүрэг нь Группын ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хүрээнд хэрэгжүүлэх юм.

Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх, түгээх

Ёс зүй, байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх нь Группын итгэл хүлээх чадвар болоод эдгээр асуудлаар үйл ажиллагаа явуулах гол үндэслэл юм.

Группийн үүрэг амлалтуудыг тусгасан энэхүү Ёс зүйн дүрэм нь Группын бүх ажилчдад хамаарна. Үүнийг бүх Maison болон Группын аж ахуйн нэгжүүдэд түгээж, шинээр орсон ажилчдад танилцуулна. Ёс зүйн дүрэм нь холбогдох Maison-ы ажилтнуудын дагаж мөрдөх ёстой Maison тус бүрийн дүрэм, бодлогыг дагалдана.

Энэхүү Ёс зүйн дүрмийг LVMH-ийн вебсайт болон Группын дотоод сүлжээнээс хэд хэдэн хэлээр татаж авах боломжтой.

Менежер бүр Ёс зүйн дүрэмд дурдсан үүрэг амлалтуудыг үлгэрчлэн дагаж мөрдөх, баг дотроо сурталчлах үүрэг хүлээнэ.

Ажилтан бүр эдгээр үүрэг амлалтыг ямар ч нөхцөлд биечлэн дагаж мөрдөх ёстой.

Тодорхой нөхцөл байдалд юу хийх ёстой талаар эсвэл тус дүрэмд тусгасан зарчмуудыг хэрхэн тайлбарлаж ойлгох талаар итгэлгүй байгаа тухайн ажилтан нь менежер, Ёс зүй, нийцлийн асуудал хариуцсан мэргэжилтэн эсвэл захиралтай холбогдоно уу (ethics@lvmh.com).

Хэрэв ажилтан энэхүү дүрэм болон холбогдох бодлогод тусгасан зарчмыг дагаж мөрдөөгүй бол түүнд тухайн үйлдлийн хүндрэлийн зэрэгт тохирсон сахилгын арга хэмжээ, шийтгэл хүлээлгэх ба шийтгэлд нь ажлаас чөлөөлөх багтаж болно.

Зөрчлийг мэдээлэх систем

LVMH нь Группын хүрээнд харилцан яриа, харилцааны соёлыг дэмждэг.

Групп нь мэдэгдэл хүлээн авах, мэдэгдлийг шийдвэрлэх хүртэл хяналт тавих тогтолцоо бүхий Группын Зөрчил мэдээлэх бодлогыг баталсан.

Холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэм эсвэл Групп болон түүний Maison-уудын бодлогод тусгасан зарчмуудыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдалтай тулгарсан аливаа ажилтан нөхцөл байдлын талаар Хүний нөөц эсвэл Хүний нөөцийн Ёс зүй, нийцлийн мэргэжилтэнд цаг алдалгүй мэдэгдэх хэрэгтэй.

Эдгээр сувгуудаас гадна LVMH нь "LVMH Зөрчлийг мэдээлэх систем" гэсэн нууцлалыг баталгаажуулсан, төвлөрсөн, зөрчлөөс сэргийлэх аюулгүй системийг бий болгосон. Тус цахим платформд Группын вебсайтаар эсвэл <https://alertline.lvmh.com> хаягаар нэвтэрч болно. Энэ нь бүх ажилчид болон гадны оролцогч талуудад нээлттэй.

Групп нь хадгалагдаж буй мэдэгдлүүдийн бүрэн бүтэн байдал, нууцлалыг хэзээд хангах болно.

Хийсэн мэдэгдэл нь үнэн зөв биш байсан ч гэсэн тус системийг сайн санааны үүднээс ашиглаж буй этгээд эсвэл шүгэл үлээгчид тусалсан эсхүл түүнтэй холбоотой хэн нэгний эсрэг хариу арга хэмжээ авахыг хориглоно.



Дэлгэрэнгүй мэдээллийг Группын Зөрчил мэдээлэх бодлогоос үзнэ үү.



Үүрэг амлалт хүлээсэн групп
Хариуцлагатай ажил олгогч
Үнэнч шударга групп

Үүрэг амлалт хүлээсэн групп

Үүрэг амлалт хүлээсэн групп

Үндсэн эрхийг эрхэмлэн дээдлэх

LVMH нь Группын үйл ажиллагаа явуулж буй аль ч газар хүний эрхийг эрхэмлэн дээдэлдэг.

Хувь хүн бүрийн нэр төрийг эрхэмлэн дээдэлнэ гэдэг нь Групп, түүний Maison-ууд болоод үйл ажиллагааны үнэт зүйлсийн салшгүй нэг хэсэг буюу байгууллагын зорилгод тавигдах амин шаардлага гэж Групп итгэдэг.

LVMH нь бүх ажилчид болон түншүүд нь энэ чиглэлээр ижил стандарт дагаж мөрдөнө гэсэн хүлээлттэй байдаг.

LVMH нь хүний хөгжил, хамгааллын гол хүчин зүйлс болох нийгэм ба эрүүл мэндийн нөхцөл байдлыг тогтмол сайжруулахад дэмжлэг үзүүлдэг.

Тухайлбал, LVMH нь цалин хөлс шударга, эрх тэгш байдлыг хангахыг эрмэлздэг. Групп нь Maison-ууд болон тэдгээрийн түншүүд, ханган нийлүүлэгчдийн дагаж мөрдөх ёстой арван таван зарчимд суурилсан цалин хөлсний шударга ёсны бодлогыг (Цалин хөлсний шударга ёсны зарчим) боловсруулсан.

LVMH нь нөлөөллийнхөө хүрээнд олон улсын хамтын нийгэмлэгийн баталсан үндсэн зарчим, эрх, эрх чөлөө, нэн ялангуяа Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын сүүр конвенциуд, ЭЗХАХБ-ын Үндэстэн дамнасан компаний удирдамжийн IV бүлэг зэргийг түгээн дэлгэрүүлдэг.

Групп нь хуулийн дагуу өөрийн бизнесийн нийгэмд үзүүлж болох шүүд болон шүүд бус сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ба шаардлагатай тохиолдолд үүнээс сэргийлэхийн тулд сонор сэрэмжтэй ажиллана.

Тиймээс LVMH-ийн бизнесийн загвар нь хүний эрх, үндсэн эрх чөлөө, хувь хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчныг хүндэтгэхтэй нийцэж байхыг хангах үүднээс Сонор сэрэмжтэй ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан.

LVMH-ийн бүх ажилчид ажил үүргээ гүйцэтгэхдээ хүний эрхийг өдөр тутам сахин биелүүлж, түгээн дэлгэрүүлнэ.



Дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах:

- Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрэм;
- Группын Сонор сэрэмжтэй ажиллагааны төлөвлөгөө (Бүх нийтийн бүртгэлийн баримт бичиг);
- LVMH-ийн Нийгэм, байгаль орчны хариуцлагын тайлан

Хүрээлэн буй орчныг хамгаалах

LVMH нь байгаль орчныг хүндэтгэдэг бөгөөд НҮБ-ын Даян дэлхийн гэрээний арван зарчим болон холбогдох Тогтвортой хөгжлийн зорилтуудыг дагаж мөрддөг.

LVMH нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилгоор хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг хязгаарлаж, эерэг арга хэмжээг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Бидний учруулж буй хүрээлэн буй орчны нөлөөллийн шууд болон шууд бус тооцооллыг тусгах үүднээс тогтмол шинэчлэгддэг LIFE (LVMH-ийн Хүрээлэн буй орчны санаачлага) хөтөлбөр нь Группын байгаль орчныг хамгаалах хариуцлагатай, ирээдүйд чиглэсэн арга барил бүхий үйл ажиллагааны бодит биелэл юм. LIFE хөтөлбөр нь дөрвөн стратеги төлөвлөгөөнөөс бүрддэг бөгөөд үүний хүрээнд тодорхой хугацаанд биелүүлэх нарийн зорилтуудыг тавьдаг. Байгалийн нөөц баялгыг хамгаалахын зэрэгцээ бүтээгдэхүүний тогтвортой байдал, үе дамжин өвлөгдөх чадварыг сайжруулах тойрог, бүтээлч эдийн засгийн аргуудыг хэрэгжүүлэх үүднээс эдгээр зорилтуудыг Группын бүх Maison-ууд хэрэгжүүлдэг.

- **Бүтээлч тойрог чанарыг хөгжүүлэх**

Групп нь бүтээгдэхүүнийхээ байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд LVMH-ийн суурь үнэ цэнэ болох бүтээлч байдлыг ашигладаг. LVMH нь аливаа зүйлийг бүтээлчээр дахин ашиглах, дахин боловсруулах, даавуу, арьс ширний үлдэгдлийг ашиглах, шинэ процессыг хөгжүүлэх замаар нийгэмд сэтгэл татам хэмээгддэг зүйлсийн талаарх ойлголтыг өөрчлөхөд туслах шинэ бүтээлүүдийг бий болгодог.

- **Биологийн олон янз байдлыг хамгаалах**

Группын Maison-уудын бүтээгдэхүүн бүрийг онцгой болгодог зүйл бол байгалийн баялаг юм. Тиймээс экосистемийг хамгаалах, нөхөн сэргээх, усны хомсдолтой тэмцэхэд шинжлэх ухаанд суурилсан олон түншлэлийн хүрээний урт хугацааны үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай.

- **Уур амьсгалын өөрчлөлтийн талаар авах арга хэмжээ**

Группын уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг зорилтуудын хүрээнд дотоод чиг үүрэг (худалдан авалт, ложистик, жижиглэнгийн худалдаа, студи гэх мэт) эсвэл гадаад түншүүд болон ханган нийлүүлэгчид байхаас үл хамааран LVMH болон түүний Maison-ууд бизнесийн салбар бүрийн эрсдлийн бодит байдлыг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, оролцогч талуудаа дайчлан ажилладаг.

- **Ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний үл мөрийг мөрдөн тогтоох ба ил тод байдлыг хангах**

Ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний үл мөрийг мөрдөн тогтоох гэдэг нь хариуцлагатай үйл ажиллагааг баталгаажуулах урьдач нөхцөл бөгөөд энэ нь ханган нийлүүлэлтийн гинжин хэлхээний алхам бүр хүчтэй, хатуу хянах тогтолцоотой байхыг шаарддаг. Тиймээс LVMH нь Олон улсын нийгэм, хүрээлэн буй орчны магадлан итгэмжлэл, шошгын холбоо (ISEAL)-ны тодорхойлолтыг нэвтрүүлсэн бөгөөд энэ нь "баталгаажсан үйлдвэрлэлийн нэгж ба эцсийн бүтээгдэхүүний талаарх баримтын хоорондын үл мөрийг мөрдөн тогтооход ашигладаг цогц баримт бичиг, механизмын мэдлэгт үндэслэсэн болно".

LVMH-ийн бүх ажилчид эрчим хүч хэмнэх, биологийн олон янз байдлыг хүндэтгэх алхмуудыг хийж, Группын мэдлэг, сургалтын хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцох хэрэгтэй.



Дэлгэрэнгүй мэдээлэл авах:

- LIFE 360 хөтөлбөр;
- Группын Сонор сэрэмжтэй ажиллагааны төлөвлөгөө (Бүх нийтийн бүртгэлийн баримт бичиг);
- LVMH-ийн Нийгэм, байгаль орчны хариуцлагын тайлан

Түншүүд болон ханган нийлүүлэгчдийн дунд хариуцлагатай хандлагыг сурталчлах

LVMH нь өөрийн үнэ цэнийн гинжин хэлхээний гол холбоос болох түншүүд болон ханган нийлүүлэгчиддээ хариуцлагатай хандлагыг төлөвшүүлэх, хөгжүүлэхийг эрмэлздэг тул Групп нь шилдэг чанар, инноваци, түүштай байдлын үнэт зүйлсээ хуваалцахыг зорьдог.

Түүнчлэн LVMH нь түншүүд болон ханган нийлүүлэгчиддээ нийгэм, байгаль орчны шаардлагатай арга барилыг бий болгон, дагаж мөрдөхөд туслахын сацуу эдгээр асуудлаарх гарч ирж буй шинэ зүйлсийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Тодруулбал, LVMH нь түншүүд болон ханган нийлүүлэгчидтэй байгуулсан гэрээндээ LVMH-ийн Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрэмд тусгасан зарчмуудыг дагаж мөрдөх шаардлага тавихаас гадна тэд Группийн нэрийн өмнөөс бизнес эрхлэхдээ өөрсдийнхөө түншүүд болон ханган нийлүүлэгчдэд ижил шаардлага тавихыг хангадаг.

Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрэмд дараахь зүйлсийг тусгасан:

- Группын нийгмийн хариуцлагын стандартууд;
- LVMH-ээс тавьсан байгаль орчны хувьд шийдвэрлэх асуудлууд;
- Группын бизнесийн ёс зүй, шударга байдлын шаардлага;
- Түншүүд болон ханган нийлүүлэгчид санал гомдлын механизмтай байх хэрэгцээ шаардлага болоод LVMH Зөрчил мэдээлэх шугамд хандах боломжтой байх;
- LVMH-ийн түншүүд болон ханган нийлүүлэгчиддээ хяналт тавих, тэдний эзэмшилд байгаа мэдээлэлд хандах эрх; ба
- Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх тухай түншүүд болон ханган нийлүүлэгчдийн гэрээ.

Түнш эсвэл ханган нийлүүлэгч нь Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхгүй байгаа тохиолдолд тухайн ханган нийлүүлэгчтэй бизнес хийж буй Группын нэгжүүд зөрчил дутагдлыг засч залруулахыг шаардах, худалдан авалтаа түдгэлзүүлэх, хүргэлтийг хүлээн авахаас татгалзах, засч залруулах арга хэмжээ авах хүртэл аливаа барааг буцаах эсвэл бусад эрх, эрх чөлөөнд хохирол учруулахгүйгээр тус түнш, ханган нийлүүлэгчтэй бизнесийн харилцаагаа цуцалж болно.

Нэмж дурдахад, энэхүү Ёс зүйн дүрэм, Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрэм ба/эсвэл холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн (эсвэл зөрчих эрсдэлтэй) талаар мэдэж буй аливаа түнш, ханган нийлүүлэгчид санаа зовж буй асуудлаа мэдэгдэх нь зүйтэй. LVMH Группын холбоо барих хаяг руу эсвэл LVMH Зөрчил мэдээлэх шугамаар дамжуулан мэдэгдлээ илгээнэ үү.

LVMH-ийн бүх ажилчид хамтран ажилладаг түншүүд болон ханган нийлүүлэгчид нь Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрэмд тусгасан зарчмуудыг дагаж мөрдөхийг зөвшөөрч байгаа эсэхийг баталгаажуулна.



Дэлгэрэнгүй мэдээллийг Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрмээс үзнэ үү.

Хариуцлагатай ажил олгогч

Хариуцлагатай ажил олгогч

Эелдэг, хүртээмжтэй ажлын орчныг дэмжих

Бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх

LVMH нь ажилчдаа үндэс угсаа, үндэстэн, нийгэм, соёлын гарал үүсэл, хүйс, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээл, нас, гэр бүлийн байдал, шашин шүтлэг, үлс төрийн итгэл үнэмшил, үйлдвэрчний эвлэлийн харьяаллаар ялгаварлан гадуурхалгүйгээр эрхээ эдлэхийг хангах үүрэг хүлээсэн.

Ажилчиддаа эрх тэгш хандах нь LVMH-ийн хөдөлмөрийн болон нийгмийн олон янз байдлыг хүндэтгэх хүний нөөцийн бодлогын гол бүрэлдэхүүн хэсэг юм. Групп нь ажилд авах, цалин хөлс, ажлын цаг, ажлаас чөлөө авах болон цалинтай чөлөө олгох, жирэмсний болон амаржсаны хамгаалал, ажлын байрны баталгаа, томилолт, үнэлгээ, сургалт, ажил мэргэжлийн хэтийн төлөв, хөдөлмөрийн эрүүл мэнд ба аюулгүй байдал гэх мэт бүхий л асуудлын хүрээнд аливаа ялгаварлан гадуурхалтыг хориглодог.

LVMH-ийн нийт ажилчид бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалттай тэмцэж, энэ тал дээр үлгэр жишээ биеэ авч явах тухай Группын үүрэг амлалтаа дагаж мөрдөх ёстой.

Хүчирхийлэлтэй тэмцэх

LVMH нь зан үйл, үйлдэл, дохио зангаа эсвэл бичгээр илэрхийлсэн бүхий л төрлийн айлган сүрдүүлэлт, доромжлол, заналхийлэл, хүчирхийлэл, бие махбод, бэлгийн, аман эсвэл ёс суртахууны дарамтыг эрс эсэргүүцдэг.

LVMH-ийн нийт ажилчид нэг нэгэндээ болон хөндлөнгийн оролцогч талуудад хүндэтгэлтэй хандана.

Хүртээмжтэй соёлыг төлөвшүүлэх

Олон янз байдал нь биднийг бүтээлч байдал, амжилтанд хөтөлдөг ба энэ нь бидний урт хугацааны амжилтад хувь нэмрээ оруулахад хүн бүр хувьсан өөрчлөгдөж, шинэчлэгдэх боломжтой өвөрмөц байдлыг эрхэмлэх, хүртээмжтэй соёлыг төлөвшүүлэх амлалтын маань үр дүн юм. Энэхүү амлалт нь Группийн хийж буй бүхий л ажил хэрэг болон ажилчид, түншүүд, ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид гэх мэт талуудтай харилцах харилцаагаар биелэлээ олж байдаг.

Тодруулбал, Групп нь орон нутгийн нөхцөл байдлаас шалтгаалан эмэгтэйчүүд болон хангалттай төлөөлөлгүй бүлгүүдэд ажил мэргэжлийн хөгжилд менторын болоод идэвхтэй дэмжлэг үзүүлэх зэрэг хөтөлбөрүүдийг бий болгосон.

Түүнчлэн LVMH нь эрдэм шинжилгээний болон ашгийн бус салбаруудтай олон төрлийн түншлэл байгуулан авьяас чадварыг эртнээс хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

Тус Групп нь ахмад настнуудад зориулан сургалт явуулах, ажлын цаг, нөхцөлийг тэдэнд нийцүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжиж, үр чадварыг өвлүүлэн авах үйл явцад хувь нэмрээ оруулдаг.

LVMH нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авах үүрэг амлалтыг чандлан сахидаг бөгөөд тусгай санаачилга, түншлэлээр дамжуулан тэднийг сургах, ажилд авах, ажилтай байлгахад идэвхтэй дэмжлэг үзүүлдэг.

LVMH-ийн нийт ажилчид өдөр тутмын үйл ажиллагаандаа дотооддоо болон түншүүд, ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид болон бусад хөндлөнгийн оролцогч талуудтай харилцахдаа Группын хүртээмжтэй байдлын үүрэг амлалтыг биечлэн үлгэрлэнэ.



Дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах:

- Ажилд авах ёс зүйн дүрэм;
- LVMH-ийн Нийгэм, байгаль орчны хариуцлагын тайлан.

Ажлын байран дээрх амьдралын чанарыг хангах

LVMH нь ажилчдынхаа карьерын туршид ажил мэргэжлийн хөгжил, ажлын амьдралын чанарыг баталгаажуулдаг.

Ажлын байран дээрх тав тухтай байдал

LVMH нь ажилчдадаа ажлын байран дээрээ амжилттай ажиллаж, бүрэн хүчин чадлаараа хөгжих шаардлагатай нөхцлийг бүрдүүлдэг.

LVMH нь менежерүүдээ хамтран ажиллах, уян хатан ажлын арга барилыг хөгжүүлэх, багийн гишүүдийнхээ санаачлага, үр чадвар, хариуцлага хүлээх чадварыг хөгжүүлэхийг дэмждэг.

Менежер тус бүр итгэлцлийн уур амьсгалыг бий болгох, бүтээлч яриа хэлэлцээ хийх, багийн гишүүн бүрийн оруулсан хувь нэмрийг хүлээн зөвшөөрөхөд онцгой анхаарал хандуулах ёстой.

Групп нь ажилчид болон түншүүдийнхээ санал хүсэлтийг анхаарч үздэг. Группын ажилчдыг төлөөлөх байгууллагуудтай хэлэлцсэний үр дүнд бий болсон LVMH Heart Fund нь бүх ажилчдад нээлттэй. Энэ нь тэдэнд нийгмийн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй дэмжлэг үзүүлэхээс гадна хэрэв тодорхой шаардлагуудыг хангасан тохиолдолд санхүүгийн яаралтай тусламжийг санал болгодог.

Эрүүл ажил амьдралын тэнцвэртэй байдал

LVMH нь ажилчдынхаа ажил амьдралын тэнцвэрт байдлыг хүндэтгэдэг бөгөөд энэ нь тэдний ажлын байран дээрх тав тух, амьдралын чанарт чухал ач холбогдолтой гэдгийг хүлээн зөвшөөрдөг.

Групп нь ажил, амьдралаа тусдаа авч үзэх эрхэд онцгой анхаарал хандуулдаг.

Тухайн үйл ажиллагааны хүрээнд зөвшөөрөгдсөн бол Групп ажилчдынхаа уян хатан ажлын зохицуулалтыг дэмждэг.

Ажилчдын хөгжил дэвшил

LVMH нь олон тооны сургалтын хөтөлбөр зохион байгуулж, газарзүйн хувьд зорчих хөдөлгөөнийг дэмжих замаар ажилчдынхаа хөгжил дэвшлийг хангадаг. Групп нь уламжилж ирсэн үр чадвар, гар урлал ба бүтээлч арилжааны соёлын өвийг түгээн дэлгэрүүлэхэд онцгой анхаардаг.

Ажилтан бүр өөрийн ажил мэргэжлийнхээ хувьд үндсэн үүрэг хариуцлагыг хүлээдэг ч LVMH-ийн менежерүүд болон хүний нөөцийн баг ажилчдын хөгжлийг дэмжихийн төлөө бүхнээ зориулдаг.

Менежерүүд хүндэтгэлтэй, сэтгэл ханамжтай, тав тухтай байдлыг дэмжих ажлын орчинг бүрдүүлэх ёстой. Тэд ажилчдынхаа хөгжлийг дэмжиж, тэдний санал хүсэлтийг сонсож, ажил амьдралын тэнцвэрт байдалд анхаарлаа хандуулах ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг LVMH-ийн Нийгэм, байгаль орчны хариуцлагын тайлангаас үзнэ үү.

Эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах

LVMH нь ажил олгогчийнхоо хувьд Группын ажлын байр эсвэл Группын төлөө ажиллаж байгаа өөрийн ажилчид болон бүх хүмүүст аюулгүй, сэтгэл хангалуун ажлын орчинг бүрдүүлэх нь Группын үүрэг хариуцлага гэж ухамсарладаг.

LVMH нь ажилчдынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, бизнесийн үйл ажиллагаа нь үйл ажиллагаа явуулж буй улс орны эрүүл мэндийн хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг баталгаажуулж, ажлын байрны аюулгүй байдлын шилдэг туршлагыг хэрэгжүүлэхийг эрмэлздэг.

LVMH нь "Осол гэмтэлгүй" ажлын байрны соёлыг төлөвшүүлэх зорилгоор таван бүрэлдэхүүн хэсэг бүхий Эрүүл мэнд, аюулгүй байдлын дүрмийг баталсан.

- асуудлыг тодорхойлох;
- түсгэйлсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;
- нэвтрүүлж, удирдах;
- ажилтан бүрийг оролцуулах; болон
- аюулгүй экосистемийн ёс суртахуунтай соёлыг хадгалах.

LVMH нь ажилчдаа ажлын байран дээр аюултай материалд өртөх эсвэл аюултай нөхцөл байдалд орохоос хамгаалдаг. Группын ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын дүрмийг тодорхойлсон холбогдох дотоод журмын талаар ажилчид мэдээлэл хүлээн авдаг.

Эрүүл мэндийн хямралын нөхцөлд эсвэл нийгмийн хариуцлагын стратегийн нэг хэсэг эхэсээс үл хамааран LVMH болон түүний Maison-ууд ажил зохион байгуулах, ажилчдыг дэмжих, шилдэг туршлага солилцох янз бүрийн урт хугацааны системийг боловсруулсан.

Мөн LVMH нь загвар өмсөгчидтэй ажиллах харилцаа, тэдний тав тухтай байдлын тухай дүрмийг баталж, шударга ёс, хариуцлага, тухайн хүмүүст хүндэтгэлтэй хандах өндөр стандартыг сурталчлан, тэдний ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг баталгаажуулсан.

LVMH-ийн бүх ажилчид Группын Эрүүл мэнд, аюулгүй байдлын арга барилыг даган мөрдөж, эрүүл мэнд ба/эсвэл аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөл байдалд анхаарлаа хандуулах ёстой.



Дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах:

- Эрүүл мэнд, аюулгүй байдлын дүрэм;
- Загвар өмсөгчидтэй ажиллах харилцаа, тэдний тав тухтай байдлын тухай дүрэм;
- Группын Сонор сэрэмжтэй ажиллагааны төлөвлөгөө (Бүх нийтийн бүртгэлийн баримт бичиг);
- LVMH-ийн Нийгэм, байгаль орчны хариуцлагын тайлан.

Үнэнч шударга групп

Үнэнч шударга групп

Авлигатай тэмцэх

LVMH нь дэлхийн аль ч хэсэгт үйл ажиллагаа явуулснаас үл хамааран авлигыг үл тэвчих бодлого баримтална.

LVMH болон түүний Maison-ууд нь авлигын гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх ба авлигын гэмт хэрэг үйлдсэн эсвэл эрх мэдлээ ашиглан давуу эрх олгосон тохиолдолд шийтгэх оноох арга хэмжээ авна.

Групп нь ажилтнуудад авлигын үйлдэл байж болзошгүй, эсвэл эрх мэдлээ ашиглан давуу эрх олгосон байж болзошгүй, улмаар хориглосон янз бүрийн арга барилыг тодорхойлоход туслах зорилгоор Авлигатай тэмцэх дүрмийг баталсан. Тухайлбал, аливаа бэлэг болон үрилгэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Авлигатай тэмцэх дүрэм нь ажилтнуудад зөв хариу үйлдэл хийх чадварыг хөгжүүлэхэд нь туслах бодит жишээнүүдийг тусгасан байдаг.

Дүрмээс гадна сургалтыг Группын бүх ажилчдад, тэр дундаа авлига, эрх мэдлээ ашиглан давуу эрх олгох хамгийн өндөр эрсдэлтэй ажилчдад зориулан явуулдаг.

LVMH нь түншүүд болон ханган нийлүүлэгчдээсээ ижил дүрмийг дагаж мөрдөн, авлига эсвэл эрх мэдлээ ашиглан давуу эрх олгох эрсдэлтэй аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийтгэх зохих арга хэмжээ авахыг шаарддаг.

LVMH-ийн бүх ажилчид Авлигатай тэмцэх дүрэмд тусгасан дүрмүүдийг дагаж мөрдөх ёстой бөгөөд энэ тал дээр онцгой анхаарал болгоомжтой ажиллах ёстой.

Группын бизнесийн түншүүдтэй хамтран ажилладаг ажилтнууд эдгээр түншүүд нь Авлигатай тэмцэх дүрэм болоод Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрмийн зарчмуудыг дагаж мөрдөж буйг хангах ёстой.



Дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах:

- Авлигатай тэмцэх дүрэм;
- Ханган нийлүүлэгч ба бизнесийн түншийн ёс зүйн дүрэм.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх

Ашиг сонирхлын зөрчил гэдэг нь Группийн ажилтны хувийн ашиг сонирхол нь Группын эсвэл түүний аль нэг Maison-ий ашиг сонирхолтой зөрчилдөж буй эсвэл зөрчилдөж болзошгүй нөхцөл байдал юм. Иймэрхүү нөхцөл байдлын учруулж болзошгүй эрсдэлийг арилгах, бууруулахын тулд ёстой мэдээлж, зохицуулах ёстой.

Ажилтан бүр болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг үнэлэхдээ өөрийн хувийн нөхцөл байдлын талаар сайтар дүгнэлт хийж, ийм зөрчлийн тухайд өөрсдийн харьяалагдах Maison-ий дотоод журмын дагуу менежер ба/эсвэл холбогдох хэлтэс(үүд)-т нэн даруй мэдэгдэх үүрэгтэй (Ёс зүй ба нийцлийн, Хүний нөөц, Хууль эрх зүй).

LVMH-ийн бүх ажилчид бизнес эрхэлж, ажлаа үнэнч шударгаар хийх ёстой. Ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй ажилчид тухайн зөрчлийн талаар нэн даруй мэдэгдэх ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг Авлигатай тэмцэх дүрмээс үзнэ үү.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх

Мөнгө угаах гэдэг нь хууль бусаар олсон орлогын эх үүсвэрийг хууль ёсны эх сурвалжаас олсон мэт харагдуулан, нуун дарагдуулах явдал юм.

Групп нь үйл ажиллагаагаа мөнгө угаах хэрэгсэл болгон ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд үйл ажиллагаагаа явуулж буй улс орон бүрт зохих арга хэмжээг авч, бэлэн мөнгө төлөхийг хязгаарлах эсвэл энэ талаар зааварчилгаа өгөх, мөн ажилчид болон түншүүдээ мөнгө угаах эрсдэлд анхаарлаа хандуулахыг шаарддаг.

LVMH-ийн бүх ажилчид мөнгө угаахтай тэмцэх дүрмийг дагаж мөрдөх ёстой бөгөөд ялангуяа борлуулалтын ажилтнуудын хувьд бэлэн мөнгөний төлбөртэй холбоотой босгыг дагаж мөрдөх ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг дотоодын Мөнгө угаахтай тэмцэх бодлогоос үзнэ үү.

Олон улсын хориг арга хэмжээг дагаж мөрдөх

LVMH нь олон улсын хориг арга хэмжээ, экспортын хяналтын тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд онцгой ач холбогдол өгдөг.

Дүн хэмжээнээс үл хамааран Группын гүйлгээ бүрийг дараах байдлаар анхааралтай хянадаг.

- олон улсын хориг арга хэмжээнд өртөж буй улс орон, бүс нутгуудтай шууд болон шууд бүс харилцаа холбоо буй эсэхийг тодорхойлох;
- тухайн гүйлгээ нь олон улсын хориг арга хэмжээний жагсаалтад нэр нь орсон аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнтэй холбоогүй эсэхийг шалгах; ба
- экспортын хяналттай холбоотой аливаа хязгаарлалтыг дагаж мөрдөх.

LVMH-ийн бүх ажилчид олон улсын хориг арга хэмжээ, экспортын хяналтын дэглэмд хамаарах хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд онцгой анхаарах ёстой.

Иймэрхүү зохицуулалтын нарийн төвөгтэй байдлыг харгалзан ажилтнууд экспортын хяналттай холбоотой олон улсын хориг арга хэмжээ эсвэл хязгаарлалтад хамрагдсан улс орон эсвэл бүс нутагтай холбоотой аливаа гүйлгээ хийхээсээ өмнө өөрийн харьяалагдах Ёс зүй ба нийцлийн мэргэжилтэнтэй холбоо барих ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг Олон улсын хориг арга хэмжээний дотоод бодлогоос үзнэ үү.

Чөлөөт, гажуудалгүй өрсөлдөөнийг дэмжих

LVMH нь холбогдох хууль тогтоомж, арга барилын дагуу чөлөөт, гажуудалгүй өрсөлдөөнийг дэмжиж, Группийн бизнес эрхэлдэг улс орон бүрт мөрдөгдөж буй өрсөлдөөний дүрмийг ажилтнууд дагаж мөрдөж буйг хангахыг эрмэлзэнэ.

LVMH нь өрсөлдөөний хууль тогтоомжийг даган мөрдөх жинхэнэ соёлыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой Өрсөлдөөний тухай хуулийн дотоод дүрэмд өрсөлдөөнийг дагаж мөрдөх хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэг амлалтаа албан ёсоор тусгасан.

Энэхүү дүрэм нь ажилчдын өдөр тутмын бизнесийн харилцаандаа дагаж мөрдөх үндсэн дүрэм, түүнчлэн тэдний биелүүлэх ёстой стандартуудын бодит жишээг тусгасан болно.

LVMH нь ямар ч нөхцөлд эдийн засгийн хараат байдлыг урвуулан ашиглах, хууль бус мэдээлэл солилцох, картель эсвэл өрсөлдөгчдийн хооронд үнэ, нутаг дэвсгэр, зах зээлийн хувьцаа, үйлчлүүлэгчидтэй холбоотой гэрээ, төлөвлөгөө, зохицуулалт, зохион байгуулалттай үйл ажиллагаагаар дамжуулан хийгдэх хууль бус хуйвалдааныг хүлээн зөвшөөрөхгүй.

Тодруулбал LVMH нь давамгайлах байр сууриа урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхийг эрмэлздэг.

LVMH-ийн бүх ажилчид өрсөлдөөний хуулийг чандлан дагаж мөрдөх ёстой. Группийн өрсөлдөгчидтэй харилцах харилцааг сайтар нягталж, нийт ажилчид өрсөлдөөнийг гажуудуулах аливаа арга хэмжээ авахаас татгалзах ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг Өрсөлдөөний тухай хуулийн дотоод дүрмээс үзнэ.

Нууцлал хадгалах

LVMH-ийн ажилтнууд олон нийтэд ил болгоогүй дотоод мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдлыг хамгаалах ёстой.

Уг мэдээлэлд санхүүгийн мэдээлэл эсвэл стратеги, ажилчид, үйлчлүүлэгчид, цуглуулга, бүтээгдэхүүний нээлт, боломжит худалдан авалт эсхүл бидэнд өрсөлдөх давуу талыг бий болгох арилжааны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл багтаж болно.

Ерөнхийдөө нууцлал нь Групп доторх болон бидний түншүүд болон үйлчлүүлэгчидтэйгээ харилцах харилцаанд итгэх итгэлийг хадгалах гол түлхүүр юм. LVMH нь Группт өгсөн гадны бүх нууц мэдээллийг хамгаалж, ийм мэдээллийг зөвхөн зөвшөөрөгдсөн зорилгоор ашиглаж, зохих бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг.

Ялангуяа LVMH нь харилцаа холбооны арга хэрэгсэл ашиглан нэвтэрч болзошгүй зөвшөөрөлгүй хувь хүмүүс эсвэл тэд санамсаргүй сонсож болзошгүй газар ажилтнууд дотоод мэдээллийг задруулахгүй байхыг шаардлага тавьдаг.

Мөн LVMH нь ажилчиддаа Нийгмийн сүлжээний хэрэглэгчийн дотоод гарын авлагад заасны дагуу ажилчид интернетэд санал бодлоо илэрхийлэхдээ маш болгоомжтой хандах, нэн ялангуяа илэрхийлсэн санал бодол тухайн хувь хүний санал бодол гэдгийг тодотгох, сэтгэл хөдлөлөө барих, бусдыг хүндэтгэх ба аливаа нууц мэдээлэл эсвэл худалдааны нууцыг задруулахгүй байх шаардлага тавьдаг.

Тодруулбал, компьютержсэн харилцаа холбооны арга хэрэгслийг ашиглана гэдэг нь Maison-уудын кибер аюулгүй байдлын дүрэмд тусгасан дүрэм, зарчмуудыг дагаж мөрдөнө гэсэн үг юм.

LVMH-ийн бүх ажилчид олж мэдсэн дотоод болон гадаад нууц мэдээллийг Группээс гадуурх хэн нэгэнд эсвэл тухайн мэдээллийн талаар ажлын байрны хүрээнд мэдлэгтэй байх шаардлагагүй LVMH-ийн ажилтнуудад шууд болон шууд бусаар задруулахаас зайлсхийх ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг Нийгмийн сүлжээний хэрэглэгчийн дотоод гарын авлагаас үзнэ.

Санхүүгийн зах зээлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, дотоод мэдээлэл ашиглан арилжаа хийхээс урьдчилан сэргийлэх

Санхүүгийн зах зээлийн бүрэн бүтэн байдал нь эдийн засгийн тогтвортой байдлын түлхүүр юм.

LVMH нь зах зээлийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, зах зээлийг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй. Тодруулбал, LVMH нь зах зээлд худал мэдээлэл өгөх эсвэл санхүүгийн хэрэгсэл ашиглан үнийг хуурамч үндэслэлээр өөрчлөхөд хүргэж болох ямар нэгэн үйлдэл хийхгүй.

LVMH-ийн хувьцааг санхүүгийн зах зээл дээр арилжаалдаг тул дотоод мэдээлэлтэй холбоотой хуулийн хариуцлага хүлээдэг.

“Дотоод мэдээлэл” гэдэг нь олон нийтэд ил болгоогүй, нэг буюу хэд хэдэн үнэт цаас гаргагч, эсхүл нэг буюу түүнээс дээш тооны үнэт цаас гаргагчийн гаргасан нэг буюу хэд хэдэн санхүүгийн хэрэгсэлтэй шууд болон шууд бус хамааралтай нарийн мэдээлэл ба хэрэв уг мэдээллийг нийтэд ил болговол тухайн санхүүгийн хэрэгсэл эсвэл түүнтэй холбоотой үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэт цаасны үнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлж болох юм.

Ийм мэдээллийг эзэмшсэн хэн тухайн мэдээлэл нь олон нийтэд ил тод болоогүй бол тухайн үнэт цаас гаргагчийн хувьцааг (эсвэл холбогдох санхүүгийн хэрэгслийг) шууд болон шууд бусаар эсхүл зуучлагчаар дамжуулан худалдан авах, худалдахаас татгалзах ёстой. Мөн тэд мэдээлэл задруулахгүй байх өндөр үүрэг хариуцлага хүлээнэ.

Групп нь тухайн мэдээлэл нь дотоод мэдээлэл мөн эсэхийг тодорхойлох мөн олон нийтэд хүргэхийг хойшлуулах эсэх шийдвэр гаргах журамтай. Хэрэв мэдээллийг олон нийтэд мэдээлэх асуудлыг хойшлуулахаар шийдсэн бол тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авч, дотоод мэдээлэл бүрийн хувьд хэн мэдээлэлтэй болохыг тодорхойлно.

Дотоод мэдээлэлтэй ажилчид дотоод мэдээллийн солилцооноос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дүрэм журмыг дагаж мөрдөх ёстой. Тодруулбал, тэд нь тухайн санхүүгийн хэрэгсэл (үүд)-тэй холбоотой хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцохгүй бөгөөд холбогдох мэдээллийг задруулахгүй байх ёстой.

Хувь хүний нууцыг хүндэтгэх

LVMH нь үйлчлүүлэгчид болон ажилтнуудынхаа (“өгөгдлийн субъект”) хувь хүний нууцад ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд үүнийг хамгаалах, ялангуяа тэдний хувийн мэдээллийг хамгаалахад хамгийн өндөр анхаарал хандуулдаг.

Иймд LVMH нь Хувь хүний нууцын дүрэмдээ заасан зургаан үндсэн зарчмыг баримталдаг ба энэ нь өгөгдлийн субъектүүдийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, шилжүүлэх үед хаана шилжүүлж буйгаас үл хамааран тэдний эрхийг хамгаалах хамгийн наад захын зайлшгүй баталгаа юм.

Тиймээс Maison эсвэл Группын аж ахуйн нэгж бүр хаана ч байсан эдгээр зургаан үндсэн зарчим, хувийн нууц, хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомжийг дагаж мөрдөх ёстой.

Тухайлбал Maison болон Группын аж ахуйн нэгж тус бүр дараахь зүйлсийг баталгаажуулах ёстой.

- хувийн мэдээллийн бүхий л боловсруулалт нь хууль ёсны бөгөөд өгөгдлийн субъектийн бусад эрх, хувь хүний нэр төрд халдаагүй (“хууль ёсны зарчим”);
- хувийн мэдээлэл нь зохистой, ач холбогдолтой бөгөөд тэдгээрийг боловсруулж буй зорилгынхоо хүрээний шаардлагатай зүйлсээр хатуу хязгаарлагддаг (“ач холбогдолтой байх зарчим”);
- хувийн мэдээллийг зөвхөн цуглуулсан зорилгынхоо хүрээнд, өгөгдлийн субъектийн нууцлалыг хамгаалах байдлаар ашиглана (“тэнцвэрт харьцааг хангах зарчим”);
- хувийн мэдээллийн амьдралын мөчлөгийн явцад учирч болох аливаа эрсдлийг тодорхойлж, үнэлж, баримтжуулснаар ийм эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хамгаалах арга хэмжээ авах боломжтой (“аюулгүй байдлын зарчим”);
- өгөгдлийн субъектүүдэд тэдний хувийн мэдээллийг хэрхэн боловсруулж буй талаар мэдээлэл өгнө (“ил тод байдлын зарчим”);
- өгөгдлийн субъектүүд хувийн мэдээлэлдээ хандах эрхээ хэрэгжүүлэх боломжтой байна (“өгөгдлийн субъектийн эрхийг хүндэтгэх зарчим”).

LVMH-ийн бүх ажилчид ажил үүргээс хамааралгүйгээр хувийн нууцлал болоод өдөр тутмын үйл ажиллагаатай нь холбогдуулан цуглуулж, боловсруулсан хувийн мэдээллийг хүндэтгэх ёстой. Ажилтан бүр Хувийн нууцлалын дүрэмд заасан зарчим бүрийг дагаж мөрдөх ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг Хувийн нууцлалын дотоод дүрмээс үзнэ үү.

Олон нийтийн ажилд хариуцлагатай оролцох

LVMH нь зөвхөн улс төрийн удирдагчид гэлтгүй холбогдох талуудтай бүтээлч яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны үүднээс төрийн бодлогын хэлэлцүүлэгт оролцдог.

Хууль, дүрэм журмыг дагаж мөрдөх нь олон нийтийн мэтгэлцээнд оролцох үед Группын итгэл хүлээх байдлын урьдач нөхцөл юм.

Нэмж дурдахад, нэгдмэл, ил тод, үнэнч шударга байх нь Группын олон нийтийн үйл ажиллагаанд оролцох гол зарчмууд юм.

Ялангуяа LVMH нь хэлэлцүүлгийн түншүүддээ өгсөн мэдээллийн найдвартай байдалд ихээхэн ач холбогдол өгдөг бөгөөд бизнесийн хүрээнд шаардлагатай тохиолдолд "сонирхлын төлөөлөгч" (лоббичин)-ийн бүртгэлтэй байдаг. Группын гадны үйлчилгээ үзүүлэгчид ижил дүрмийг дагаж мөрдөх ёстой.

Групп нь ажилчдынхаа улс төрийн болон үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаанд хувь хүний байр сууринаас оролцох эрхийг хүндэтгэдэг. Гэсэн хэдий ч ажилчид хувийн үйл хэрэг нь үүргээ биелүүлэхэд нь саад учруулахгүй, эсвэл Группын нэр хүндийг гэмтээхгүй байхыг хангана.

LVMH нь улс төрийн нам, улс төрийн болон эвлэлийн байгууллагад мөнгө өгөхийг хориглодог.

LVMH нь үндэсний болон Европын парламентын аль нэг гишүүнийг сонгогдсон бүрэн эрхийнх нь хугацаанд тогтмол болон түр хугацааны цалин хөлс олгох ба ажилд авахыг хориглодог.

Олон нийтийн салбарт LVMH эсвэл Maison-ийг төлөөлж буй LVMH-ийн бүх ажилчид шударга, ил тод, үнэн зөв ажиллах ёстой.



Дэлгэрэнгүй мэдээллийг Хариуцлагатай лоббины дотоод дүрмээс үзнэ үү.